# ТАНИЛЦУУЛГА

2023 оны жилийн эцсийн байдаар иргэдээс нутгийн Захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай

Булган аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан нээлттэй утас, саналын хайрцаг ажиллуулах журам болон иргэдээс тавьсан асуудалтай холбоотой хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, дүрэм журмыг баримтлан ажиллаж байна.

Иргэдээс 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт **9213** өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснээс АЗДТГ-т 296 иргэн хандаж өргөдөл гомдол гаргасан нь 3,21 хувь, харьяа агентлагт 41,6 хувь буюу 3783, сумдын ЗДТГ-т 5128 иргэн хандаж өргөдөл гомдол гаргасан нь 55,6 хувийг эзэлж байна.

Энэ улиралд иргэдээс Засаг даргын тамгийн газарт гаргасан 296 өргөдлийг шийдвэрлэхээр судлан танилцаж, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл гомдол гараагүй байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл хүсэлтийг цаг хугацаа орон зайнаас үл хамааран гаргах нөхцөл боломжийг бүрдүүлж аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудас /www.bulgan.gov.mn/-аар өргөдөл гомдол хүлээж авах цэс бий болсон бөгөөд одоогийн байдлаар иргэдээс цахимаар санал хүсэлт ирүүлээгүй байна.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**Хүснэгт №1**

## 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

| Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлт /Хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | | |
| Аймгийн ИТХ | 6 | 6 | - | - | - | **100%** |
| Аймгийн ЗДТГ | 296 | 296 | - | - | - | **100%** |
| Харьяа агентлаг | 3783 | 3654 | 63 | 2 | 64 | **96,5%** |
| Сумдын ЗДТГ | 5128 | 3849 | 198 | 38 | 1043 | **75,05%** |
| **Аймгийн нийт дүн** | **9213** | **7805** | **261** | **40** | **1107** | **92,8%** |

**Хүснэгт №2**

## 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

| Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдлын тоо | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| Аймгийн ИТХ | 6 | 6 | | | | - |
| Аймгийн ЗДТГ | 296 | 203 | 93 | | | - |
| Харьяа агентлаг | 3783 | 417 | 119 | 129 | 3118 | - |
| Сумдын ЗДТГ | 5128 | 393 | 406 | 159 | 4170 | - |
| **Аймгийн нийт дүн** | **9213** | **1019** | **618** | **288** | **7288** | **-** |

**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА**

| | | |
|---|---|---|
| 1 | Булган | Нийт өргөдлөөс 9213 1. Хүсэлт – 8566/ 92,9%<br>2. Санал - 74/ 0,8 %<br>3. Гомдол – 415 / 4,8%<br>4. Мэдэгдэл- 158/ 1,7 %<br><br>Аймгийн хэмжээнд мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 203 иргэн хүсэлт ирүүлсэн бөгөөд сумдын Засаг даргын нөөц хөрөнгө хангалтгүй тул бүх иргэдэд тусламж үзүүлэх боломжгүй байна.<br>Харин энэ оны жилийн эцсийн байдлаар Аймгийн Засаг даргад хандаж сургалтын төлбөр болон эмчилгээний зардалд тусламж, дэмжлэг хүссэн 203 иргэний өргөдлийг судлан шийдвэрлэж, хариуг өглөө.<br>Аймгийн Засаг даргын захирамжаар эмчилгээний зардалд шаардлагатай 15, сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн 31, орон байр хүссэн 2, бусад 36, нийт 84 иргэнд 116,530,508 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүлж, 365,800,000 төгрөгийн үнэ бүхий Хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийг ХАА-н 2 компанид олгосон байна. |

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫ ГАЗАР